

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар хийсэн ажлын тайлан

(Нийслэлийн эрүүл мэндийн газар)

Тус газраас төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд иргэдээс гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах,хүн хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж зохион байгуулав.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд “Өргөдөл гомдлын гомдлын шийдвэрлэлтийн 2026 оны төлөвлөгөө” батлуулан ажиллаж байна. Өргөдөл гомдлын тайланг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн эрүүл мэндийн газар нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт хамт олны хуралдаан гурван удаа хуралдаж, хуралдаанаар цаг үеийн мэдээ мэдээлэл, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, үүрэг даалгаврыг өгсөн. 2026.06.11-ний өдрийн нийт хамт олны хурлаар өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн системд зөрчилтэй албан хаагчдыг танилцуулж, дахин зөрчил гаргахгүй байхыг хурлын тэмдэглэлээр сануулсан.

Төлөвлөгөөний дагуу төрийн үйлчилгээний шат дамжлага,хугацаа, хүнд суртлыг бууруулах иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах, гомдлын агуулгад дүн шинжилгээ хийж, гомдлыг бууруулах мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, албан хаагчдаас болон үйлчилгээ авч буй иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авсан.

2026 оны 04 дүгээр сард албан хаагчдаас ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн судалгааг 16 асуултын хүрээнд авахад 51 албан хаагч хамрагдсан бөгөөд энэ нь нийт ажилтнуудын 53,6 хувь нь хамрагдсан байна. Судалгааны үр дүнг газрын болон удирдлагын багт танилцуулсан. (Судалгааг хавсралтаар хүргүүлэв.)

Иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгаанд нийт 155 анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх өрх/тосгоны эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд 6436 хэрэглэгч үнэлгээнд хамрагдсан байна. Дундаж үнэлгээ 89.3% буюу 4.46-тай үнэлэгдсэн нь жилийн эцсийн үнэлгээнээс 0.7% буюу 1.2-р өссөн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа лавлагаа шатлалын 23 байгууллагаар 4165 хэрэглэгч үнэлгээнд хамрагдсан байна. Хагас жилийн байдлаар дундаж үнэлгээ нь 4.2 байна. Энэ нь жилийн эцсийн үнэлгээ (3.2)-ээс 1.0 үнэлгээгээр өссөн байна. Цаасан хэлбэрээр харьяа лавлагаа шатлалын 23 эрүүл мэндийн байгууллага 6225 хүнээс авч, эерэг сэтгэл ханамжийн хувь 84.6% байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1124 хүнээр нэмэгдсэн ба эерэг сэтгэл ханамжийн хувь 1.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 155 анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх өрх/тосгоны эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд 8693 үйлчлүүлэгч сэтгэл ханамжийн үнэлгээ авч дундаж үнэлгээ 87.6%-тай үнэлэгдсэн байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар цаас болон цахим хэлбэрээр нийт 178 эрүүл мэндийн байгууллагаас 25519 хэрэглэгчээс үнэлгээ авч эерэг үнэлгээний хувь 86.1% тай байна.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ил тод ажлын хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох 7 асуумжтай судалгаанд манай байгууллагаар үйлчлүүлсэн 60 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж, байгууллагын үйл ажиллагаанд өгсөн дундаж үнэлгээ 3,6 буюу “дунд” үнэлгээ авсан бөгөөд үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах үүднээс иргэдэд үзүүлдэг үйлчилгээний танилцуулга, зөвлөмжийг видео бичлэгээр цахим хуудаст байршуулан ажиллаж байна.

<https://www.emg.ub.gov.mn/home>

Байгууллагын албан ёсны фэйсбүүк пэйж хуудсаар иргэдэд эрүүл мэндийн чиглэлийн мэдээ мэдээлэл, үйл ажиллагааны сурталчилгаа, зөвлөмж, сэрэмжлүүлэг, богино хэмжээний дүрс бичлэг болон зурагт постыг тогтмол хүргэн ажилласан.


Тайлант хугацаанд нийт 175 төрлийн богино хэмжээний дүрс бичлэг, зурагт пост нийтэлж, давхардсан тоогоор 1,163,410 хүнд хүрч, нийт 6,177,338 хандалт авсан байна.

Цахим мэдээллийн сувгаар дамжуулан байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд шуурхай хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах чиглэлээр идэвхтэй ажиллаж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Мөн иргэдэд төрийн үйлчилгээг ойлгомжтой, тодорхой, түргэн шуурхай хүргэхээр "Тусгай зөвшөөрөл авах заавар" болон "Өргөдөл, гомдол гаргах заавар" бүхий видео контентуудыг бэлтгэн цахимаар түгээсэн. Үүний үр дүнд тусгай зөвшөөрөл авах заавар бүхий бичлэг 1544, өргөдөл гомдол гаргах заавар бүхий бичлэг 6180 хандалт тус тус авч, иргэдийг төрийн үйлчилгээний шаардлагатай мэдээллээр шуурхай, хүртээмжтэй хангаж ажиллаж байна.

Мөн Харьяа дүүргийн 8 эрүүл мэндийн төв, 5 нэгдсэн эмнэлэг, 5 төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага, 155 өрхийн эрүүл мэндийн төвүүд байгууллагын цахим хуудсандаа үзүүлж буй үйлчилгээний талаарх видео танилцуулга, эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн авах тухай алхмууд, мэдээ мэдээлэл гарын авлага бэлтгэн байршуулж сурталчилж байна.

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС АВАХ ЦАХИМ СУДАЛГАА 2026 он



Нийслэлийн Эрүүл мэндийн газар

June 11 at 5:43 PM · 🌐

...

Нийслэлийн Эрүүл мэндийн газарт Өргөдөл, Гомдол, Санал хүсэлтээ хэрхэн гаргах вэ?



Boost this post to get more reach for Нийслэлийн Эрүүл мэндийн газар.

Boost reel

Нийслэлийн Эрүүл мэндийн газар

Details

Closed now

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн засаг захиргааны III байр, Ulaanbaatar, Mongolia, 15170

Links

ub.gov.mn

Contact info

+976 7799 0101

info@emg.ub.gov.mn

Нийслэлийн Эрүүл мэндийн газар

Highlights

Collection

ХПВ-ийн халдвар

Маскаа зүүцгээ

Тарваган тахал

Edit highlights

14

1

1

Tungalag Terbish

Найз сайн уу, амжилт хүсье

25m Like Reply

Comment as Нийслэлийн Эрүүл мэндийн газар

Нийслэлийн Эрүүл мэндийн газар

Published by Б. Төвшөө · 1h ·

Тусгай зөвшөөрлийн хүснэгтийг цахимаар хэрхэн гаргах вэ?

www.tzmoh.gov.mn хүсэлт илгээх заавар

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

1-р алхам: Интернэт хөтөч дээрээ www.tzmoh.gov.mn гэж бичээд сайт руу орно.

0:09 / 2:00

See insights

Create ad

3

2

Comment as Нийслэлийн Эрүүл мэндийн газар

- Шинэ мэдээ
- Зураг төсөл хянуу...
- Хяналт шалгалты...
- Тайлангийн магт...
- Видео мэдээ
- Гадаад хамтын а...



ЧӨЛӨӨЛЬЕ

2026/06/16 46




БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ЭРҮҮЛ АХУЙН ДҮГНЭЛТ
ГАРГУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

2026/06/16 58



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР
ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

2026/06/12 95



ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

2026/05/12 332



АРХИ, ТАМХИ ХУДАЛДАН БОРЛУУЛАХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ

2026/06/16 56



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭСД ХҮСЭЛТ
ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

2026/06/12 49



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ ӨРГӨДӨЛ,
ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТЭЭ ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

2026/06/12 24



ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

2026/02/25 293